



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021-39-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг:

Ахлах аудитор: П.Мөнхтуяа

Утас: 70342716

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХАК	Хувийн аудитын компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт

## **Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	3
3.Аудитын тайлан.....	21
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	21
3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ .....	21
3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ .....	21
3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ.....	22
3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	22
3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ .....	23
3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ .....	23
3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	23
3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	24
Залруулсан алдаа.....	24
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	24
Аудитын зөвлөмж.....	25
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	25
4. Менежментийн захидал .....	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	26

- 1.Төрийн аудитын санал, дүгнэлт**
  - 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
    - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
    - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
    - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
    - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
    - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
    - 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**
-



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 103  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭМТ-ИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ П.САНДАГДОРЖ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020222

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>74,677,345.26</u></b>	<b><u>40,634,285.92</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,677,345.26	40,634,285.92
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19,912,976.59	13,765,725.45
35110	Тусгай зориулалттай материал	7,870,357.49	7,996,912.95
35130	Эм боох материал	12,042,619.10	5,768,812.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	54,764,368.67	26,868,560.47
35410	Бичиг хэргийн материал	936,000.00	543,600.00
35420	Аж ахуйн материал	29,951,146.77	20,062,976.77
35430	Сэлбэг хэрэгсэл	1,047,500.00	-
35440	Түлш, шатах тослох материал	18,737,145.00	-
35460	Хүнсний материал	4,092,576.90	6,261,983.70
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>361,337,277.68</u></b>	<b><u>336,243,441.42</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	361,337,277.68	336,243,441.42
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	346,457,277.68	321,363,441.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	486,968,641.86	486,968,641.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(277,606,588.13)	(285,910,966.37)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,144,434.00	92,144,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,637,077.84)	(37,641,150.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	132,101,971.90	112,288,060.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72,360,218.74)	(54,936,267.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,305,820.89	38,207,820.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,459,706.26)	(29,757,131.82)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		14,880,000.00	14,880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,880,000.00	14,880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>436,014,622.94</u></b>	<b><u>376,877,727.34</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b><u>679,690.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	679,690.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	679,690.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	679,690.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>436,014,622.94</u></b>	<b><u>376,198,037.34</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	436,014,622.94	376,198,037.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,351,125.19	276,351,125.19
51101	Өмч: - төрийн	276,351,125.19	276,351,125.19
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(41,864,911.07)	(101,681,496.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(41,864,911.07)	(41,864,911.07)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(59,816,585.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,528,408.82	201,528,408.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>436,014,622.94</u></b>	<b><u>376,877,727.34</u></b>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>708,904,855.55</b>	<b>502,258,723.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>91,935,585.55</b>	<b>29,332,103.72</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	91,935,585.55	29,332,103.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,935,585.55	29,332,103.72
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	91,935,585.55	29,332,103.72
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		<b>616,969,270.00</b>	<b>472,926,620.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	611,783,500.00	404,911,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	404,856,500.00	-
131011	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,927,000.00	404,911,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278,500.00	16,881,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	23,467,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,907,270.00	27,667,220.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>412,808,109.09</b>	<b>562,075,309.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,808,109.09</b>	<b>562,075,309.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>410,332,083.98</b>	<b>559,517,321.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>272,693,083.00</b>	<b>319,615,999.90</b>
210101	Үндсэн цалин	199,249,500.00	204,495,369.90
210102	Нэмэгдэл	54,662,138.00	94,805,230.00
210104	Урамшуулал	18,781,445.00	20,315,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,093,299.89</b>	<b>40,391,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,231,300.00	27,606,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,499.89	3,196,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,172,400.00	2,556,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	543,100.00	639,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,431,000.00	6,392,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,855,875.00</b>	<b>39,282,788.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,814,875.00	2,917,143.00
210302	Түлш, халаалт	6,041,000.00	36,365,645.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,980,430.00</b>	<b>22,092,865.00</b>
210401	Бичиг хэрэг	1,808,800.00	3,979,820.00

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	8,662,630.00	10,012,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	704,000.00	952,015.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	791,200.00	4,742,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,800.00	2,098,240.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,000.00	307,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,471,723.45</b>	<b>74,556,217.92</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,103,930.45	60,948,004.72
210502	Хоол, хүнс	5,344,293.00	5,965,213.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,500.00	7,643,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>985,000.00</b>	<b>8,018,954.54</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,372,554.54
210604	Урсгал засвар	985,000.00	5,646,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,512,200.00</b>	<b>838,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,512,200.00	838,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,094,585.00</b>	<b>10,575,467.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,849,835.00	9,968,567.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	606,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	116,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,250.00	-
210807	Газрын төлбөр	40,500.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,645,887.64</b>	<b>44,145,728.86</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,752,074.00	2,199,503.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	444,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,493,813.64	41,501,825.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,476,025.11</b>	<b>2,557,988.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>280,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	280,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,476,025.11</b>	<b>2,277,988.10</b>

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,476,025.11	2,277,988.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>296,096,746.46</u></b>	<b><u>(59,816,585.60)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>296,096,746.46</u></b>	<b><u>(59,816,585.60)</u></b>

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>616,969,270.00</u></b>	<b><u>472,926,620.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>616,969,270.00</u></b>	<b><u>472,926,620.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	611,783,500.00	404,911,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	404,856,500.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,927,000.00	404,911,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	278,500.00	16,881,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278,500.00	16,881,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	23,467,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	23,467,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	4,907,270.00	27,667,220.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,907,270.00	27,667,220.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>407,628,270.00</u></b>	<b><u>469,926,620.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>407,628,270.00</u></b>	<b><u>469,926,620.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>405,152,244.89</u></b>	<b><u>467,368,631.90</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	273,402,850.00	319,615,999.90
210101	Үндсэн цалин	204,193,804.00	203,154,299.90
210102	Нэмэгдэл	50,840,396.00	96,146,300.00
210104	Урамшуулал		

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		18,368,650.00	20,315,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,093,299.89	40,391,300.00
210201	Тэтгэврийн даатгал	23,231,300.00	27,606,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,499.89	3,196,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,172,400.00	2,556,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	543,100.00	639,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,431,000.00	6,392,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,503,775.00	19,895,143.00
210301	Гэрэл, цахилгаан	1,547,169.00	2,545,299.00
210302	Түлш, халаалт	18,956,606.00	17,349,844.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,909,360.00	17,052,705.00
210401	Бичиг хэрэг	1,460,000.00	1,460,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,281,510.00	10,039,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	704,000.00	952,015.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,914,350.00	3,101,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	549,500.00	1,499,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	32,580,216.00	50,737,314.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,773,226.00	40,033,084.00
210502	Хоол, хүнс	4,160,990.00	7,488,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,646,000.00	3,215,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,395,900.00	4,553,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,535,400.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,860,500.00	3,053,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,498,200.00	838,000.00
210702	Дотоод албан томилолт	1,498,200.00	838,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,615,380.00	10,575,467.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,262,630.00	9,968,567.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	606,900.00

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	116,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,250.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210807	Газрын төлбөр	40,500.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,153,264.00</b>	<b>3,709,103.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,153,264.00	3,709,103.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,476,025.11</b>	<b>2,557,988.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	280,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	2,277,988.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,277,988.10
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,476,025.11	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,476,025.11	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>209,341,000.00</u></b>	<b><u>3,000,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,414,000.00</b>	<b>3,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,414,000.00</b>	<b>3,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,414,000.00	3,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,414,000.00	3,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(2,414,000.00)</u></b>	<b><u>(3,000,000.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих		
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
145008	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
145009	Төрөл бүрийн хандив		
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
<b>24</b>	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	-	-
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр		
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр		
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр		
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	-	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
250005	Төлсөн ногдол ашиг		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(131,034,657.53)		346,844,876.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(131,034,657.53)	-	346,844,876.48
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр					

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	дүн	-	-	89,169,746.46		89,169,746.46
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(41,864,911.07)	-	436,014,622.94
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(41,864,911.07)	-	436,014,622.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(41,864,911.07)	-	436,014,622.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(59,816,585.60)		(59,816,585.60)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(101,681,496.67)	-	376,198,037.34

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	437306500.00	407566244.89	467009000.00	453854969.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437306500.00	405152244.89	467009000.00	452354969.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436306500.00	405152244.89	466279000.00	452274969.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273558100.00	273402850.00	319616000.00	319615999.90
210101	Үндсэн цалин	199249500.00	204193804.00	203154300.00	203154299.90
210102	Нэмэгдэл	55784700.00	50840396.00	96146300.00	96146300.00
210103	Унаа хоолны				

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хөнгөлөлт				
210104	Урамшуулал	18523900.00	18368650.00	20315400.00	20315400.00
210105	Гэрээт ажлын хөлс				
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34093300.00	34093299.89	40391300.00	40391300.00
210201	Тэтгэврийн даатгал	23231300.00	23231300.00	27606700.00	27606700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2715500.00	2715499.89	3196200.00	3196200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2172400.00	2172400.00	2556900.00	2556900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	543100.00	543100.00	639200.00	639200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5431000.00	5431000.00	6392300.00	6392300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22795000.00	20503775.00	21595000.00	19895143.00
210301	Гэрэл, цахилгаан	3249000.00	1547169.00	3249000.00	2545299.00
210302	Түлш, халаалт	19050000.00	18956606.00	17850000.00	17349844.00
210303	Цэвэр, бохир ус	496000.00	0.00	496000.00	0.00
210304	Байрны түрээс				
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21967100.00	13909360.00	19840800.00	17052705.00
210401	Бичиг хэрэг	1460000.00	1460000.00	1460000.00	1460000.00
210402	Тээвэр, шатахуун	15678800.00	9281510.00	11271500.00	10039240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	704,900.00	704,000.00	986,800.00	952,015.00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,623,400.00	1,914,350.00	3,122,500.00	3,101,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	549,500.00	3,000,000.00	1,499,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	38,287,300.00	32,580,216.00	41,841,900.00	35,914,814.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,777,300.00	26,773,226.00	30,331,900.00	26,620,584.00
210502	Хоол, хүнс	7,940,000.00	4,160,990.00	7,940,000.00	6,078,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,570,000.00	1,646,000.00	3,570,000.00	3,215,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал</b>				

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	<b>засварын зардал</b>	4,872,000.00	3,395,900.00	4,872,000.00	4,553,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	1,535,400.00	3,000,000.00	1,500,000.00
210602	Тавилга				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	1,872,000.00	1,860,500.00	1,872,000.00	3,053,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,838,200.00	1,498,200.00	900,400.00	838,000.00
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	1,838,200.00	1,498,200.00	900,400.00	838,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,340,900.00	14,615,380.00	13,608,600.00	10,575,467.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,781,900.00	14,262,630.00	12,726,600.00	9,968,567.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	108,000.00	882,000.00	606,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	116,000.00	116,000.00	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,500.00	22,250.00	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	66,000.00	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ				
210807	Газрын төлбөр	40,500.00	40,500.00	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх				
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,554,600.00	11,153,264.00	3,613,000.00	3,437,941.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,554,600.00	11,153,264.00	3,613,000.00	3,437,941.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	-	-	-	-

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2111	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	-	-	-	-
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр				
2112	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	-	-	-	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр				
212	<b>ТАТААС</b>	-	-	-	-
2121	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	-	-	-	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас				
2122	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	-	-	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас				
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,000,000.00	-	730,000.00	80,000.00
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	-	730,000.00	80,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж				
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал				
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт				
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-	730,000.00	80,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>2,414,000.00</b>	-	<b>1,500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	2,414,000.00	-	1,500,000.00
220001	Барилга байгууламж				
221001	Их засвар				
222001	Тоног төхөөрөмж	-	2,414,000.00	-	1,500,000.00
223001	Бусад хөрөнгө				
224001	Стратегийн нөөц хөрөнгө				
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	-	-	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр				
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл				
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл				
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл				
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	437,356,500.00	407,287,744.89	-	456,045,220.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	380,189,500.00	380,016,199.89	-	404,911,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-		-	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	380,189,500.00	380,016,199.89	-	404,911,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	24,667,000.00	22,364,275.00	-	23,467,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	24,667,000.00	22,364,275.00	-	23,467,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН</b>				

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	<b>ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	32,500,000.00	4,907,270.00	-	27,667,220.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих				
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,500,000.00	4,907,270.00	-	27,667,220.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	-
122001	Хандив тусламж /дотоод/				
122002	Хандив тусламж /гадаад/	-	-	-	-
<b>14</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	-	-
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх				
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>			-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30.00	30.00	30.00	26.00

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	25.00	25.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	4.00	-
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00		
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	-	-	-
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	-	-	-	-

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Сандагдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах,үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Гурванбулаг сумын ЭМТ нь тайлант хугацаанд “Хамт олны оролцоо хүн бүрийн үнэтэй санал, санаачилга -Бид бүгдийн хамтын ажиллагаа” гэсэн зорилго дэвшүүлж үүний хүрээнд доорх зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

1. Нээлтэй шударга байх
2. Бусдыг хүндэтгэж өөрийгөө хүндлүүлэх чадвар
3. Мэргэшсэн мэргэжилтэн
4. Итгэл хүлээлгэх чадвар
5. Үйл ажиллагааны төгөлдөршил гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй, байгууллагын НБББББ-ийг шинэчлэн боловсруулсан байна.

#### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Гурванбулаг сумын ЭМТ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэн боловсруулжээ.

ХАК нь 2020 онд Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 613.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 104.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 509.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, мянган төгрөгийн зөрчлийг хязгаарлажээ.

Зөвлөмжийн хариуг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр биелэлтийг ирүүлэхээр менежментийн захидлаар хүргүүлсэн байна.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж дуусгавар болсон тайланд дурдсан байна.

Мөн ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-д тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 283859.9 мянган төгрөгийн 2 хувиар буюу 5677.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон төлөвлөж, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 562075.3 мянган төгрөгийн зардлаас 2 хувиар буюу 11241.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59136.9 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	74677.3	40634.3	-34043.0
Үндсэн хөрөнгө	361337.3	336243.4	-25093.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>436014.6</b>	<b>376877.7</b>	<b>-59136.9</b>
Өр төлбөр		679.7	679.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	436014.6	376198.0	-59816.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>436014.6</b>	<b>376877.7</b>	<b>-59136.9</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй.

Авлага данс үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 40634.3 мянган төгрөг болж өмнөх оноос 34043.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлт нь тухайн жилд нийт 93059.4 мянган төгрөгийн бараа материалыг нэмэгдүүлж 127102.5 мянган төгрөгийн материал зарцуулсантай холбон үзэж байна.

Тухайн жилд төсвийн хөрөнгөөр 77135.3, ЭМГ-аас 15924.1 мянган төгрөг буюу нийт 93059.4 мянган төгрөгийн материалыг орлого авч тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 744488.9 мянган төгрөг болж 24911.9 мянган төгрөгөөр буурсан нь 41319.9 мянган төгрөгийн хөрөнгийг хасагдуулж дахин үнэлсэнтэй холбон үзэж байна.

Тухайн онд элэгдлээ бүрэн нөхсөн 41319.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж 13407.9 мянган төгрөгөөр үнэлэн хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлж тайлагнажээ.

Өр төлбөр дансны үлдэгдлийг 679.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 502258.7 мянган төгрөгийн орлого байгаа нь өмнөх оноос 206646.1 мянган төгрөгөөр буюу 29.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй буюу хандивын материалын үзүүлэлт буурсан өөрчлөлт байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 149267.2 мянган төгрөгөөр буюу 36.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хуримтлагдсан үр дүн өмнөх оны хуримтлагдсан үр дүнгээс 29353.2 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтэйгээр тайлагнажээ.

### **3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 404911.0, ЭМДСангаас 35549.8, орон нутгийн төсвөөс 28467.0 буюу нийт 468897.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулж санхүүжүүлэхээр улсын төсвөөс 404911.0, ЭМДСангаас 27667.2, нэмэлт санхүүжилтийн дансаар 16881.4 мянган төгрөг буюу нийт 472926.6 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 470648.7 мянган төгрөгийг зарцуулж 2277.9 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 470648.7 мянган төгрөг буюу 99.5 хувийг зарцуулж батлагдсан санхүүжилтийг бүрэн хэмжээнд зарцуулсан байна.

#### **Улсын/орон нутгийн/төсөвт төвлөрүүлэх орлого**

Өөрийн орлогыг төлөвлөөгүй болно.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр 16881.4 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 16793.7 мянган төгрөгийг зарцуулж 87.7 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

### **3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлж ажилласан байна.

### **3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 613.8 мянган төгрөгийн зөрчлөөс 104.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 509.3 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг тус тус биелүүлсэн байна.

Хүснэгт 3: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мян/төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	104.5	1	104.5			
Албан шаардлага	0	0	0	0			
Зөвлөмж	2	509.3	2	509.3			
Нийт дүн	3	613.8	3	613.8			

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9315.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 874.1 мянган төгрөгийн зөрчилд 4 акт тогтоож, 477.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар 7964.1 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 14880.0 мянган төгрөгийн алдаатай бичилтийг залруулж ажиллалаа.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1351.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 874.1 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоон, 477.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Тус сумын ЭМТ-ийн эмийн зарцуулалтыг нярвын орлогын тайлан, харилцагч байгууллагын нэхэмжлэх дүнтэй түүвэрлэн тулгахад 432400 төгрөгийн эмийг орлогод аваагүй, илүү шилжүүлж авлагын тайланд тусгаагүй мөн харилцагч байгууллагатай тооцоо нийлж ажиллаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн хүнсний зарцуулалтыг нярвын орлогын тайлан, харилцагч байгууллагын нэхэмжлэх дүнтэй түүвэрлэн тулгахад 265800 төгрөгийн хүнсний материалыг орлогод аваагүй, илүү шилжүүлж авлагын тайланд тусгаагүй мөн харилцагч байгууллагатай тооцоо нийлж ажиллаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сумын ЭМТ-ийн томилолтын зардлыг анхан шатны баримттай түүвэрлэн шалгахад томилолтын хуудасгүй, томилолтын хоног, буудлын мөнгийг 80000 төгрөгөөр илүү олгосон зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д ” Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4. Тус байгууллагын шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахууны даргын цохолт илүү 95900 төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д ” Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5. Тус сумын ЭМТ нь ЭМГ-аас олгосон 477378 төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг орлогод авч тайлагнаагүй, мөн санхүүгийн программ хангамжийг үндсэн хөрөнгийн тайлан бүртгэлд бүртгэж тайлагнаагүй зөрчлүүд илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” ”Эд хариуцагчийн хүлээх үүрэгт “Ажиллаж байгаа байгууллагынхаа дотоод дүрэмд захирагдаж өөрийн гүйцэтгэх ажил үүрэг, сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь биелүүлж удирдлагад тайлагнаж мэдээллээр ханган тэдэнтэй байнга хамтран ажиллана”, “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.”, НББОУС 16.15 “Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан хөрөнгүүдийг өртгөөр үнэлж бүртгэнэ” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар эмийн орлого зардлыг гүйцэтгэлтэй түүвэрлэн авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайн байгууллагын эмийн зардлаас хоолны зардал шилжүүлэх, эмийн орлогыг дутуу тусгасан асуудлууд анхаарал татахуйц байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан хүнсний өглөгийг 679.7 мянган төгрөгийг харилцагч байгууллага иргэдийн нэхэмжлэх болон шилжүүлсэн мөнгөн дүнтэй тулгахад 111.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, хагас бүтэн жилээр харилцагч байгууллагууд иргэдтэй тооцоо нийлж ажиллаагүй байна.

1.2 Эрсдэл: Төсөв хүрэлцэхгүй өр авлага үүсэх

1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг мөрдөж төсвийг төлөвлөхдөө оновчтой төлөвлөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Санхүүгийн тооцоог харилцагч байгууллагуудтай нийлж алдаа зөрчлийг арилгаж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа тендер шалгараагүй компаниас 2382950 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

2.2 Эрсдэл: Хууль журам зөрчигдөх

2.3 Өгсөн зөвлөмж: ЭМГ-аас өгсөн зөвлөмж тендерт шалгарсан компаниас худалдан авалт хийх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа тендерт шалгарсан байгууллагаас худалдан авалт хийж зөрчилгүй арилгана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Бичиг хэрэг, нярав, эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтны ажил хавсарсны нэмэгдлийг олгох бүтэц орон тоог баталсан боловч тухайн албан тушаалын үндсэн цалингаас тооцох хувиар тушаал шийдвэр гаргаагүй, сувилагч, баг эмчийн үндсэн цалингаас сар бүр олгохоор 455.8 мянган төгрөгөөр жилд 5469.9 мянган төгрөгийг төлөвлөн батлуулж байгууллагын дарга тушаал гаргалгүй нэмэгдэл олгожээ.

3.2 Эрсдэл: Өр авлага үүсэх

3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.3 дахь заалтыг мөрдөж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид хавсран нэмэгдэл олгоход эрүүл мэндийн төвийн даргын тушаал гаргаж алдаа зөрчил арилгаж ажиллана.

Дээрх 3 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Гурванбулаг сумын ЭМТ	Аудитын код:
2020			САГ-2021/39/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

**Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Томилолтын хуудасгүй, томилолтын хоног, буудлын мөнгийг илүү олгосон.	80.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
2	Шатахууны зардлын үлдэгдлийг өглөг авлагаар тусгаагүй тооцоо нийлж ажиллаагүй. Даргын цохолт анхан шатны баримттай тулгахад илүү шатахууны цохолт хийж зарцуулсан.	95.9	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
3	Няравын тайлангаас хүнсний материалын орлогыг, шилжүүлсэн мөнгөн дүнтэй тулгахад хүнс орлогод аваагүй, авлагаар тусгаж тайлагнаагүй зөрчил илэрлээ	265.8	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
4	Эмийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад харилцагч байгууллага руу 432400 төгрөгөөр илүү шилжүүлж авлагаар тусгаагүй, санхүүгийн тодруулга тайланд илүү, нярвын орлого дутуу зэрэг зөрчлүүд илэрлээ.	432.4	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
5	Программ хангамж болон нярвын программыг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж тайлагнаагүй, ЭМГ-аас хандиваар олгосон 477378 төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг орлогод аваагүй байна.	477.3	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
6	Санхүүгийн тайланд тусгагдсан хүнсний өглөгийг харилцагч байгууллага иргэдийн нэхэмжлэх болон шилжүүлсэн мөнгөн дүнтэй тулгахад 111.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, хагас бүтэн жилээр харилцагч байгууллагууд иргэдтэй тооцоо нийлж ажиллаагүй байна.	111.3	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
7	Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа тендер шалгараагүй компаниас худалдан авалт хийсэн байна.	2382.9	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
8	Бичиг хэрэг, нярав, эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтны ажил хавсарсны нэмэгдлийг олгох бүтэц орон тоог баталсан боловч тухайн албан тушаалын үндсэн цалингаас тооцох хувиар тушаал шийдвэр гаргаагүй, сувилагч, баг эмчийн үндсэн цалингаас сар бүр олгохоор 455.8 мянган төгрөгөөр жилд 5469.9 мянган төгрөгийг төлөвлөн батлуулж байгууллагын дарга тушаал гаргалгүй нэмэгдэл олгожээ.	5469.9	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	П.Сандагдорж, Д.Баасанхүү
<b>ДҮН</b>		<b>9315.5</b>			

**АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:**  
**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** **Д.АНХБАЯР**  
**МЕНЕЖЕР** **Ж.ЭНХЦООДОЛ**

**АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:**  
**АХЛАХ АУДИТОР** **П.МӨНХТУЯА**